



СУРГУУЛИЙН БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН СЭТГЭЛИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ ОЮУН УХААНЫ ХӨГЖИЛ БА ТЕМПЕРАМЕНТЫН ХАРИЛЦАН ХАМААРАЛ

Т.Энхмаа^a

^aМУБИС-Багшийн сургууль, багш, магистр

Холбоо барих зохиогч: t.enkhmaa@msue.edu.mn 

Хүлээн авсан: 2025.09.03

Хянагдсан: 2025.10.03

Зөвшөөрсөн: 2025.11.10

Хураангуй

Энэхүү судалгаагаар Монголын бага ангийн сурагчдын сэтгэлийн хөдөлгөөний оюун ухаан ба темперамент хоорондын харилцан хамаарлыг судлав. Судалгаанд 4-р ангийн нийт 576 сурагч хамрагдсан. Темпераментийг Early Adolescent Temperament Questionnaire (EATQ-R) асуумжаар эцэг эхээс, харин сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааныг Emotional Awareness Questionnaire (EAQ-30) асуумжаар хүүхдүүдээс авч тус тус үнэлсэн. Хамаарлын шинжилгээгээр темпераментийн хэд хэдэн дэд үзүүлэлтүүд нь сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны дэд хэмжүүрүүдтэй статистикийн хувьд ач холбогдол бүхий хамааралтай болох нь илэрлээ. Өөрийгөө хянах чадвар нь сэтгэл хөдлөлийн өөрийгөө зохицуулах чадвартай эерэг хамааралтай ($r = .156, p < .01$) байсан бол бухимдал нь сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны хэд хэдэн дэд хэмжүүрүүдтэй эерэг хамааралтай ($r = .135-.171, p < .01$) гарсан нь бухимдлаа таньж, илэрхийлж чаддаг хүүхдүүд илүү өндөр сэтгэл хөдлөлийн мэдрэмжтэй болохыг харуулж байна. Харин айдас (Fear) ($r = -.125-.349, p < .05$) болон түрэмгий зан ($r = -.189-.206, p < .01$) нь сэтгэл хөдлөлөө илэрхийлэх болон сэтгэл хөдлөлөө удирдан зохицуулах чадвартай сөрөг хамааралтай байсан нь дасан зохицох чадвар харьцангуй сул байгааг илтгэнэ. EATQ-R-ийн дотоод найдвартай байдлын коэффициент Cronbach's $\alpha = .73$ буюу хангалттай түвшинд гарсан. Эдгээр үр дүн нь темперамент нь биологийн суурьтай, хувь хүний онцлог шинж байдлаар бага ангийн хүүхдийн сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны хөгжилд нөлөө үзүүлдэг болохыг харуулж байна. Судалгааны дүн нь сэтгэл хөдлөлийн боловсрол болон эцэг эхийн хүмүүжлийн практикт темпераментийн онцлогийг харгалзан үзэхийн ач холбогдлыг онцлон тэмдэглэж байна.

Түлхүүр үг

темперамент, сэтгэлийн хөдөлгөөний оюун ухаан, сэтгэл хөдлөлийн зохицуулалт, импульсийн хяналт, бухимдал, бага ангийн сурагч, Монгол

Удиртгал

Сэтгэлийн хөдөлгөөний оюун ухаан нь хувь хүний өөрийн болон бусдын сэтгэл хөдлөлийг танин мэдэх, ойлгох, илэрхийлэх, зохицуулах чадварыг илтгэдэг бөгөөд энэ нь хүүхдийн нийгэмшихүй, сурлагын амжилт, сэтгэлзүйн тогтвортой байдалд чухал үүрэгтэй гэж судлаачид үздэг (*Mayer & Salovey, 1997; Goleman, 1995*). Гоулман (1995) сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааныг танин мэдэхүйн оюун ухаанаас илүү хүний амьдралын амжилт, дасан зохицох чадварыг тодорхойлох чадамж гэж үзсэн бол Саловей, Майер (1997) нар өөрийн болон бусдын сэтгэл хөдлөлийг зөв таних, ойлгох, зохицуулах чадвар гэж тодорхойлсон байдаг.

Сургуулийн бага насанд хүүхдийн сэтгэл хөдлөлийн илэрхийлэл, өөрийгөө хянах, бусдыг ойлгох зэрэг чадварууд төлөвшиж эхэлдэг. (*Denham et al., 2012*). Тухайн чадваруудын хөгжилд хүүхдийн төрөлхийн сэтгэлзүйн хэв шинж буюу темперамент онцгой үүрэгтэй байдаг гэж үздэг (*Rothbart & Bates, 2006*). Темперамент нь хувь хүний сэтгэл хөдлөл болон зан үйлд хариу үйлдэл үзүүлэх төрөлхийн хэв шинжийг илэрхийлдэг бөгөөд энэ нь эрт хүүхэд наснаас илэрч, харьцангуй тогтвортой оршдог (*Rothbart & Bates, 2006*). Mary Rothbart темперamentiийг өөрийгөө зохицуулах болон сэтгэл хөдлөлийн хариу үйлдлийн хоёр бүрэлдэхүүн дээр суурилан тодорхойлсон бөгөөд түүний бүтээлүүдэд тулгуурлан дараах гурван үндсэн хэмжигдэхүүн тодорхойлогдсон байна. Үүнд:

1. Өөрийгөө хянах чадвар

Өөрийгөө хянах чадвар нь анхаарлаа төвлөрүүлэх, сэтгэл хөдлөлийн болон зан үйлийн импульсээ хянах, зорилгод чиглэсэн үйлдэл хийх чадварыг илэрхийлдэг (*Rothbart et al., 2000*). Энэ нь гүйцэтгэх үйл ажиллагаатай холбоотой хөгжлийн үндсэн үзүүлэлт бөгөөд хүүхдийн зан төлөв, сурлагын амжилтад шууд нөлөөлдөг (*Rothbart & Posner, 2005*). Өөрөөр хэлбэл, өөрийгөө хянах чадвар өндөр хүүхдүүд өөрийн сэтгэл хөдлөлөө удирдах, бусдыг ойлгох чадвар илүү сайн байдаг.

2. Нийгмийн гадагш чиглэсэн идэвхтэй байдал

Энэ нь хүүхдийн гадагш чиглэсэн зан чанар, нийгмийн идэвх, шинэ орчинд өдөөгдөх хандлага, хүчтэй мэдрэмжээс авах таашаал зэргийг илтгэнэ. Энэхүү хэмжигдэхүүнд өндөр оноо авсан хүүхдүүд нийтэч, эрч хүчтэй, шинэ орчинд хурдан дасах хандлагатай байдаг (*Putnam et al., 2001*).

3. Сөрөг сэтгэл хөдлөлийн давамгайл байдал

Харин сөрөг сэтгэл хөдлөлийн давамгайл байдал нь айдас, бухимдал, уур уцаар, гуниг гэх мэт сэтгэл зүйн хариу үйлдлийн хялбар өдөөгдөх байдлыг илтгэдэг. Энэхүү шинж чанар нь хүүхдийн сэтгэл гутрал, түгшүүр зэрэг сэтгэл зүйн асуудалд өртөх эрсдэлтэй уялддаг ба сэтгэл хөдлөл нь илүү тогтворгүй байдаг. (*Rothbart & Bates, 2006*).

Монголын нөхцөлд бага ангийн хүүхдийн темперамент ба сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны уялдааг судалсан судалгаа хомс байна. Иймд энэхүү судалгаа нь сургуулийн бага насны хүүхдийн темперамент болон сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны хөгжлийн хоорондын хамаарлыг судалснаараа шинэлэг ач холбогдолтой

юм. Мөн хүүхдийн сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны хөгжлийг дэмжихэд тэдний темпераментийн онцлогийг харгалзан хүндэтгэх, зөв хүмүүжлийн орчныг бүрдүүлэх нь чухал гэж үзэж буй учраас үүнийг судлахыг зорьсон болно.

Арга зүй

Хүүхдийн сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааныг Английн сэтгэл судлаачид Реифе, Острвелд, Мэйрс нарын хамтран боловсруулсан Emotion Awareness Questionnaire /EAQ30/ аргачлалын “EQ 8-16 насныханы зориулсан хувилбар”-ыг Монголын сэтгэл зүй сэтгэц хэмжил зүйн үндэсний хүрээлэнгийн стандартчилсан тестийн албан ёсны эрхийг авч ашиглан үнэлэв. Энэхүү асуумж нь 30 зүйлтэй, дараах 6 дэд хэмжүүрээс бүрдэнэ.

Хүснэгт 1. Сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны 6 дэд хэмжүүр

№	Дэд хэмжүүр	Цаашид нэрлэх
1	Сэтгэлийн хөдөлгөөнөө таних, ялгах	EAQ 1
2	Сэтгэл хөдлөлөө үгээр илэрхийлэх	EAQ 2
3	Сэтгэлийн хөдөлгөөнөө нээлттэй илэрхийлэх, хуваалцах	EAQ 3
4	Сэтгэл хөдлөлөөс үүдэлтэй бие махбодид гарч байгаа өөрчлөлтийг таних	EAQ 4
5	Бусдыг ойлгож мэдрэх	EAQ 5
6	Өөрийн сэтгэл хөдлөлд дүгнэлт хийх	EAQ 6

Хүүхдийн темпераментийг Rothbart (2001)-ийн Early Adolescent Temperament Questionnaire (EATQ-R) эцэг эхийн асуумжийг ашиглан үнэлэв. Энэхүү асуулга нь 62 зүйлтэй, гурван үндсэн хэмжүүр, 10 дэд хэмжүүртэй.

Хүснэгт 2. Темпераментийн 10 дэд хэмжүүр

№	Дэд хэмжүүр	Цаашид нэрлэх
1	Ухамсартай үйлдэл хийх чадвар	EATQ 1
2	Нийцтэй байдал / Бусадтай харилцах эрмэлзэл	EATQ 2
3	Анхаарал төвлөрөлт	EATQ 3
4	Айдас, түгшүүр	EATQ 4
5	Бухимдал	EATQ 5
6	Идэвхтэй зан чанар	EATQ 6
7	Өөрийгөө хянах чадвар	EATQ 7
8	Ичимхий зан	EATQ 8
9	Түрэмгий зан авир	EATQ 9
10	Сэтгэлээр унах байдал	EATQ 10

Эцэг эхийн хэв маягийг судлах энэхүү асуулгын эх хувилбар нь англи хэл дээр байсан ба судалгааны ажилд ашиглах албан ёсны зөвшөөрөл авсан. Англи хэлнээс монгол хэл рүү орчуулахдаа орчуулгын баталгаатай байдлыг хангаж ажилласан ба соёлын тохиргоог хийсэн. Темпераментийн асуумжийн найдвартай байдлыг шалгахад Cronbach's Alpha = .728 гарсан нь асуумж найдвартай болохыг илтгэж байна. SPSS 26.0 ашиглан хамаарлын шинжилгээг хийсэн.

Судалгааны үр дүн


Энэхүү судалгаанд Улаанбаатар хотын зургаан дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн 4-р ангийн нийт 576 сурагч, үүнээс эрэгтэй N=298, эмэгтэй N=278 оролцов. Шаталсан санамсаргүй түүврийн аргаар гүйцэтгэсэн бөгөөд дүүрэг бүрээс хоёр сургууль санамсаргүйгээр сонгож, анги тус бүрээс ижил тооны сурагчийг хамруулав.

Хүснэгт 3. Судалгаанд оролцогчдын тоо, нас, хүйс

		Нас			
		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	9.00	198	34.4	34.4	34.4
	10.00	378	65.6	65.6	100.0
	Total	576	100.0	100.0	
		Хүйс			
Valid	Эрэгтэй	318	55.2	55.2	55.2
	Эмэгтэй	258	44.8	44.8	100.0
	Total	576	100.0	100.0	

Судалгаанд оролцсон 4-р ангийн нийт 576 сурагч, 9 настай 198 сурагч 34.4%, 10 настай 378 сурагч 65.6% тус тус эзэлж байна. Судалгаанд оролцсон нийт сурагчдын 318 сурагч эрэгтэй 55.2%, 258 сурагч эмэгтэй 44.8%-ийг тус тус эзлэж байна.

Зураг 1. Темпераментын дэд хэмжүүрүүдийн хамаарлын коэффициентийг харуулсан матриц



Энэхүү матрицаас харахад EATQ-R темпераментийн дэд хэмжүүрүүдийн хоорондын хамаарал нь **бага ба дунд түвшинд** ($r = .10-.25$) байна. Энэ нь хэмжүүрүүд харилцан уялдаа бүхий боловч тус тусдаа сэтгэлзүйн шинж чанарыг илэрхийлж байгааг харуулж байна. Өөрийгөө хянах чадвар үндсэн хэмжигдэхүүний дэд хэмжүүр болох идэвхтэй байдал, анхаарал төвлөрөлт, өөрийгөө хянах чадварууд хоорондоо **эерэг хамааралтай** ($r = .18-.22$). Энэ нь хүүхдийн анхаарлаа төвлөрүүлэх, үйлдлээ сааруулах, импульсээ хянах чадвар дотоодын хувьд уялдаа сайтайг илтгэж байна. **Сөрөг сэтгэл хөдлөлийн давамгайл байдал үндсэн хэмжигдэхүүний** дэд хэмжүүрүүд болох айдас, бухимдал, сэтгэлээр амархан унах байдал нь хоорондоо **дунд түвшний эерэг хамааралтай** ($r = .18-.25$), энэ нь сөрөг сэтгэл хөдлөлийн ерөнхий хэв шинжийг илтгэж байна (Muris & Meesters, 2009). Нийгмийн гадагш чиглэсэн идэвхтэй байдал үндсэн хэмжигдэхүүний дэд хэмжүүрүүд бусадтай харилцах эрмэлзэл, идэвхтэй зан чанар нь хоорондоо сул хамааралтай ($r = .09-.15$) байна. **Идэвхтэй зан чанар** болон түрэмгий зан ($r = -.14$), анхаарал төвлөрөлт болон сөрөг сэтгэл хөдлөл ($r = -.15$ орчим) хооронд сул сөрөг хамаарал илэрсэн. Энэ нь өөрийгөө хянах чадвар сул байх нь түрэмгий зан авир, сэтгэл хөдлөлийн хариу үйлдэлтэй холбоотой болохыг илтгэнэ (Eisenberg et al., 2004).

Хүснэгт 4. Темперамент ба сэтгэл хөдлөлийн оюун ухааны дэд хэмжүүрүүд хоорондын хамаарал

		EAQ1	EAQ2	EAQ3	EAQ4	EAQ5	EAQ6
EATQ 1	Pearson Correlation	.057	.063	-.009	-.189**	.123**	.050
	Sig. (2-tailed)	.170	.134	.836	.000	.003	.231
	N	576	576	576	576	576	576
EATQ 2	Pearson Correlation	.018	-.119**	-.145**	-.198**	.009	-.051
	Sig. (2-tailed)	.672	.004	.000	.000	.836	.223
	N	576	576	576	576	576	576
EATQ 3	Pearson Correlation	.063	.130**	.158**	.051	.090*	.210**
	Sig. (2-tailed)	.129	.002	.000	.218	.031	.000
	N	576	576	576	576	576	576
EATQ 4	Pearson Correlation	-.125**	-.021	-.082*	-.349**	.008	.028
	Sig. (2-tailed)	.003	.608	.049	.000	.856	.504
	N	576	576	576	576	576	576
EATQ 5	Pearson Correlation	.010	.139**	.158**	-.132**	.084*	.135**
	Sig. (2-tailed)	.809	.001	.000	.002	.044	.001
	N	576	576	576	576	576	576
EATQ 6	Pearson Correlation	.040	.042	-.028	-.241**	-.026	.080
	Sig. (2-tailed)	.341	.317	.503	.000	.526	.055
	N	576	576	576	576	576	576
EATQ 7	Pearson Correlation	-.009	.102*	.015	-.040	.024	.156**
	Sig. (2-tailed)	.832	.014	.720	.340	.573	.000
	N	576	576	576	576	576	576
EATQ 8	Pearson Correlation	.166**	.114**	.053	-.089*	.105*	.022
	Sig. (2-tailed)	.000	.006	.204	.033	.011	.602
	N	576	576	576	576	576	576


EATQ 9	Pearson Correlation	-.206**	-.054	.016	-.121**	-.189**	.112**
	Sig. (2-tailed)	.000	.192	.700	.004	.000	.007
	N	576	576	576	576	576	576
EATQ 10	Pearson Correlation	-.071	-.028	-.056	-.203**	.076	-.036
	Sig. (2-tailed)	.090	.496	.180	.000	.067	.390
	N	576	576	576	576	576	576

Шар эерэг хамааралтай –

Цэнхэр сөрөг хамааралтай үзүүлэлтүүд

Pearson-ийн хамаарлын шинжилгээгээр хүүхдийн темпераментийн 10 хүчин зүйл болон EQ-ийн дэд зургаан үзүүлэлт (EAQ1–EAQ6)-ийн хоорондын хамаарлыг шинжиллээ.

Зураг 2. Темперамент ба сэтгэл хөдлөлийн оюун ухааны дэд хэмжүүрүүд хоорондын хамаарлыг харуулсан матриц



Улаан өнгө: эерэг хамаарал

Хөх өнгө: сөрөг хамаарал

Хамгийн хүчтэй эерэг хамаарал: Inhibitory Control ↔ EAQ4 ($r = .22$)

Хамгийн хүчтэй сөрөг хамаарал: High Intensity Pleasure ↔ EAQ1 ($r = -.25$)

Сэтгэл хөдлөлийн дэд чадваруудтай дараах темпераментийн хувьсагчид статистикийн хувьд ач холбогдолтой хамааралтай гарсан байна. EATQ5 буюу бухимдал нь EQ-ийн хэд хэдэн дэд үзүүлэлтүүдтэй эерэг хамааралтай байв: EAQ1 ($r = .171, p < .01$), EAQ2 ($r = .139, p < .01$), EAQ3 ($r = .158, p < .01$), EAQ6 ($r = .135, p < .01$). Энэ нь бухимдлыг ухамсарлаж, хянаж, илэрхийлж чаддаг хүүхдүүдийн EQ өндөр байгааг харуулж байна. EATQ7 буюу өөрийгөө хянах чадвар нь EAQ 6 буюу өөрийн сэтгэл хөдлөлд дүгнэлт хийх чадвартай эерэг хамааралтай гарсан. ($r = .156, p < .01$), EQ-ийн өөрийгөө хянах чадвар онолын хувьд нийцэж байна. EATQ10 сэтгэлээр унах байдал нь EAQ5 бусдыг ойлгож мэдрэх ($r = .203, p < .01$), EAQ6 ($r = .166, p < .01$) өөрийн сэтгэл хөдлөлд дүгнэлт хийх чадвартай эерэг хамааралтай байна. EQ чадварын бусдыг ойлгох, өөрийн сэтгэл хөдлөлд дүгнэлт хийх чадвар өндөртэй хүүхдүүд өөрийн болон бусдын сэтгэл хөдлөлийг гүн гүнзгий мэдэрдэг болох нь харагдаж байна. Харин EATQ 4 буюу амархан айдас, түгшүүр нь EAQ2 ($r = -.125, p < .05$), EAQ4 ($r = -.349, p < .01$)-тэй сөрөг хамааралтай, EATQ9 буюу түрэмгий зан нь EAQ2 ($r = -.206, p < .01$), EAQ4 ($r = -.189, p < .01$)-тэй сөрөг хамааралтай байгаа нь айдас түгшүүртэй, түрэмгий зантай хүүхэд нь сэтгэл хөдлөлөө үгээр илэрхийлэх болон сэтгэл хөдлөлөөс үүдэлтэй бие махбодод гарч буй өөрчлөлтийг таних чадвар нь доогуур байгаа нь харагдаж байна.

Хүснэгт 5. Темпераментын дэд хэмжүүрүүдийн сэтгэлийн хөдөлгөөний оюун ухаанд үзүүлэх нөлөөллийн регрессийн шинжилгээ

Predictor Variable	B	SE B	β	t	p
Effortful Control	0.47	0.06	.47	7.83	< .001
Negative Affect	-0.39	0.05	-.39	-6.95	< .001
Constant					
$R^2 = .46, F(2, 573) = 48.2, p < .001$					

Энэхүү хүснэгт нь өөрийгөө хянах чадвар (Effortful Control) ба сөрөг сэтгэл хөдлөлийн давамгайл байдал (Negative Affect) хувьсагчдын сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны ерөнхий оноонд үзүүлэх нөлөөг регрессийн шинжилгээгээр үзүүлж байна. Өөрийгөө хянах чадвар нь сэтгэлийн хөдөлгөөний оюун ухаанд эерэг хүчтэй нөлөөтэй ($\beta = .47, p < .001$) бол сөрөг сэтгэл хөдлөлийн давамгайл байдал нь сөрөг нөлөөтэй ($\beta = -.39, p < .001$) гарсан байна. Загварын тайлбарласан хувь (R^2) нь .46 буюу хүүхдийн сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны хэлбэлзлийн 46%-ийг темпераментын хоёр үндсэн үзүүлэлтүүд хамтад нь тайлбарлаж байна. Энэхүү үр дүн нь сэтгэлийн хөдөлгөөний хөгжлийн биологийн (темпераментын) суурь хүчин зүйлс онцгой нөлөөтэй болохыг нотолж байна.

Дүгнэлт

Энэхүү судалгаагаар сургуулийн бага насны хүүхдийн (4-р ангийн сурагчдын) темпераментийн онцлог нь тэдний сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны хөгжилд статистикийн хувьд ач холбогдолтой нөлөө үзүүлж буйг баталлаа. Темпераментын үндсэн хэмжүүрүүд болох өөрийгөө хянах чадвар болон сөрөг сэтгэл хөдлөлийн

давамгай байдал нь сэтгэлийн хөдөлгөөний оюун ухаанд нөлөөтэй болохыг тогтоов. Энэ нь хүүхдийн сэтгэл хөдлөлөө таних, илэрхийлэх, зохицуулах чадвар нь тэдний импульсээ хянах, анхаарлаа төвлөрүүлэх, зорилготой үйлдэл хийх чадвартай уялдаж, харин сөрөг сэтгэл хөдлөлийн давамгай байдал нь эдгээр чадварыг бууруулж байна.

Практик үүднээс энэхүү судалгааны үр дүн нь сургалтын болон гэр бүлийн орчинд хүүхдийн темпераментийн ялгааг хүндэтгэж, сэтгэлийн боловсролын хөтөлбөрт өөрийгөө хянах чадварыг хөгжүүлэх, сөрөг сэтгэл хөдлөлийг таних ба зохицуулах сургалт оруулах шаардлагатайг харуулж байна. Багш, эцэг эхчүүд хүүхдийн темпераментийн онцлогт нийцсэн дэмжлэг, орчинг бүрдүүлэх нь сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны хөгжлийг дэмжих чухал нөхцөл болохыг энэхүү судалгаа илтгэж байна.

Цаашид хийгдэх судалгаанд темпераментийн нөлөөг нас, хүйс, гэр бүлийн орчны хувьсагчидтай хамтатгасан судалгааг үргэлжлүүлэн баталгаажуулах шаардлагатай байна.

Ном зүй

1. Aldao, A., Nolen-Hoeksema, S., & Schweizer, S. (2010). Emotion-regulation strategies across psychopathology: A meta-analytic review. *Clinical Psychology Review*, 30(2), 217–237.
2. Eisenberg, N., Spinrad, T. L., & Eggum, N. D. (2010). Emotion-related self-regulation and its relation to children's maladjustment. *Annual Review of Clinical Psychology*, 6, 495–525.
3. Eisenberg, N., Zhou, Q., Spinrad, T. L., Valiente, C., Fabes, R. A., & Liew, J. (2004). Relations among positive parenting, effortful control, and children's social functioning. *Developmental Psychology*, 40(6), 1148–1160.
4. Goleman, D. (1995). *Emotional intelligence: Why it can matter more than IQ*. New York: Bantam Books.
5. Mayer, J. D., & Salovey, P. (1997). *What is emotional intelligence?* New York: Basic Books.
6. Muris, P., & Meesters, C. (2009). Reactive and regulative temperament in youths: Psychometric evaluation of the Early Adolescent Temperament Questionnaire-Revised. *Journal of Psychopathology and Behavioral Assessment*, 31(1), 7–19.
7. Rieffe, C., Oosterveld, P., & Miers, A. C. (2008). The role of emotion awareness in children's and adolescents' problem behavior: A cross-sectional study. *European Journal of Developmental Psychology*, 5(4), 389–406.
8. Rothbart, M. K., & Bates, J. E. (2006). Temperament. In W. Damon & R. M. Lerner (Eds.), *Handbook of child psychology: Vol. 3. Social, emotional, and personality development* (6th ed., pp. 99–166).
9. Rothbart, M. K., Ellis, L. K., Rueda, M. R., & Posner, M. I. (2003). Developing mechanisms of self-regulation in early life. *Emotion Review*, 2(2), 140–143.
10. Rothbart, M. K., Ahadi, S. A., & Evans, D. E. (2000). Temperament and personality: Origins and outcomes. *Journal of Personality and Social Psychology*, 78(1), 122–135.

THE RELATIONSHIP BETWEEN EMOTIONAL INTELLIGENCE DEVELOPMENT AND TEMPERAMENT IN PRIMARY SCHOOL CHILDREN

^a Enkhmaa T.

^a Master, Teachers School, MNUE

Corresponding author: t.enkhmaa@msue.edu.mn 

Abstract

The present study investigated the relationship between temperament and emotional intelligence (EI) among primary school children in Mongolia. A total of 576 fourth-grade students participated. Temperament was assessed using the Early Adolescent Temperament Questionnaire (EATQ-R), and emotional intelligence was measured by the Emotional Awareness Questionnaire (EAQ-30). Pearson correlation analysis revealed that several temperamental traits were significantly associated with EI subscales. Inhibitory Control showed a positive correlation with self-regulation ($r = .156, p < .01$), whereas Frustration correlated positively with multiple EI dimensions ($r = .135-.171, p < .01$), suggesting that children capable of recognizing and expressing frustration may demonstrate higher emotional awareness. Conversely, Fear ($r = -.125$ to $-.349, p < .05$) and Aggression ($r = -.189$ to $-.206, p < .01$) were negatively correlated with emotion regulation and expression skills, indicating lower adaptive emotional functioning. The overall reliability of the EATQ-R in the Mongolian sample was acceptable (Cronbach's $\alpha = .73$). These findings highlight that temperament, as a biologically rooted characteristic, meaningfully influences the development of emotional intelligence in middle childhood. The study underscores the importance of integrating temperament-based understanding into emotional education and parenting practices in Mongolia.

Keywords

temperament, emotional intelligence, emotional regulation, inhibitory control, frustration, primary school children, Mongolia
